

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003оны 5дугаар
сарын 23ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 10.1.4, 10.2 дахь заалтыг үндэслэн Үнэт цаасны хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Хувьцаат компанийн санхүүгийн тайлан тэнцлийн хураангуйг хэвлэн нийтлэх, мэдээллийг нийтэд хүргэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх журмыг үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад сурталчлан, мөрдөж ажиллахыг Ажлын алба / Ж. Жадамбаа/-нд даалгасугай.

ДАРГА

С. ГҮНДЭНБАЛ

ХУВЬЦААТ КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙГ ХЭВЛЭН НИЙТЛЭХ,
МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ ЖУРАМ

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 10.1.4, 10.2 дахь заалт, “Компанийн тухай” хуулийн 93,94 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх, компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны талаар болон үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээ явцад нөлөөлөх мэдээллийг хувь нийлүүлэгчид болон нийтэд хүргэн сурталчлах, олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

НЭГ.Санхүүгийн тайлангийн
хураангуйг хэвлэн нийтлэх

1.1.Нийтэд санал болгон үнэт цаас гаргасан компаниуд аудитын байгууллагаар шалгуулж баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлангийн хураангуйг энэ журмын хавсралт №А1- ээр гаргаж өдөр тутам хэвлэгдэн гардаг аль нэг сонинд хэвлүүлэн нэг хувийг хэвлүүлсэн тухай мэдэгдлийн хамт Үнэт цаасны хороонд ирүүлнэ.

1.2.Хураангуйг хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал хуралдахаас өмнө хэвлүүлсэн байх бөгөөд түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч/түүнтэй адилтгах албан тушаалтан/ нар хариуцна.

1.3.Хорооны бүртгэл хариуцсан мэргэжилтэн тайлангийн хураангуйн үзүүлэлтийг Хороонд ирүүлсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй тулган шалгаж, буруу дутуу мэдээлсэн зүйл байвал энэ тухай компанид мэдэгдэж холбогдох эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан захиргааны хариуцлага оногдуулна.

1.4. Хорооны мэдээлэл хариуцсан мэргэжилтэн санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэн нийтлүүлсэн үнэт цаас гаргагчдын бүртгэл хөтөлнө.

~~ХОЁР. Үнэт цаасны үнэ ханш, арилжааны
хэмжээ явцад нөлөөлөх мэдээллийг
нийтэд хүргэх~~

~~2.1.Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээ явцад нөлөөлж бөлөх дор дурдсан мэдээллийг шийдвэр гарсан болон уг үйл явдал бөлөнөөс хойш ажлын 5 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.~~

~~2.1.1.Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал оорчлогдсон.~~

~~2.1.2.Дээрх хүмүүсийн эзэмшиж буй хяналтын багц хувьцаанд оорчлолт гарсан /5-аас дээш хувиар нэмэгдсэн, буедад шилжүүлсэн/~~

~~2.1.3.Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид оорчлогдсон.~~

~~2.1.4.Хараат болон охин компанитай бөлсөн, эсхүл хяналтаа алдсан.~~

~~2.1.5.Төрийн мэдэлд байсан хяналтын багц хувьцаа арилжаалагдсан.~~

~~2.1.6. Нийтэд санал болгон гаргасан аливаа үнэт цаасны гуравны нэгээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд эзэмших болоон.~~

~~2.1.7. Их хэмжээний хэлцэл хийсэн.~~

~~2.1.8. Сонирхсон зорчилтэй хэлцэл хийсэн.~~

~~2.1.9. Компанийн хуульд заасны дагуу зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөх шийдвэрийн төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталсан.~~

~~2.1.10. Нөгдөл ашиг хуваарилахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн.~~

~~2.1.11. Өрийн бичгийг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн татахаар шийдвэрлэсэн.~~

~~2.1.12. Үнэт цаас гаргагч болон түүний удирдах байгууллагын гишүүдийн үйл ажиллагаатай/компанитай холбогдох/ холбоотойгоор аливаа этгээдийг хуулийн байгууллагад гаргасан нэхэмжлэлийн дагуу хэрэг үүсгэсэн.~~

~~2.1.13. Үнэт цаас гаргагчийг дамнууруулахаар эрх бүхий этгээд шүүхэд нэхэмжлэл гаргасан.~~

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 206 дугаар тогтоолоор хүчингүй/

ГУРАВ. Мэдээллийг нийтийн хүртээл болгох

3.1. Сонирхогч бүх этгээд мэдээлэлтэй танилцах боломжийг хангасан бол мэдээллийг нийтийн хүртээл болсон гэж үзнэ.

3.2. Хууль болон энэ журамд нийтэд мэдээлэхээр заасан мэдээллийг нийтийн хүртээл болгох асуудлыг үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

3.3. Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан нийтэд хүргэж буй мэдээллийг тухайн үед Хорооны ажлын албанаас заан тогтоож, гэрээ байгуулсан аль нэг өдөр дутмын сонин эсхүл, Хороо болон Хөрөнгийн биржээс тогтмол хэвлэдэг мэдээллийн сэтгүүл, өдөр тутмын аль нэг сонинд нийтлүүлж, монголын радио, үндэсний телевизээр тус бүр 1-ээс доошгүй удаа нэвтрүүлсэн байх бөгөөд холбогдох баримтыг Хороонд ирүүлнэ.

3.4. Хорооны хариуцсан хэлтэс тухайн үнэт цаас гаргагч хууль журамд заасан мэдээллийг нийтэд хүргэсэн байдлын талаар жил тутам дүгнэж, Хорооны хуралдаанд мэдээлнэ.

ДӨРӨВ. Хариуцлага

4.1. Энэ журмын 1.1 болон 2.1-д заасан мэдээллийг нийтэд хугацаанд нь хүргээгүй үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1.1-д заасны дагуу захиргааны хариуцлага оногдуулна.

4.2. Шаардлагатай гэж үзвэл хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүртэл хугацаагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 37.2.5-д заасан арга хэмжээ авна.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРОО

Монгол улсын Үнэт цаасны хорооны 2003 оны
5 дугаар сарын 23-ний өдрийн 45 дугаар
тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн
санхүүгийн тайлан, тэнцлийн хураангуйг
хэвлэн нийтлэх, мэдээллийг нийтэд хүргэх
журам"-ын 1 дүгээр хавсралт

Маягт №А1-9

..... АЙМАГ/ХОТ/-ЫН СУМ
/ДҮҮРЭГ/-ИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ ХК-ИЙН
САНХҮҮ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 200. ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛ/ЖИЛ/-ИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ
ҮЗҮҮЛЭЛТ ДАРААХ БАЙДАЛТАЙ БАЙГААГ МЭДЭЭЛЖ БАЙНА

/Мян.төг-өөр/

Балансын зүйл	Үлдэгдэл		Балансын зүйл	Үлдэгдэл	
	Эхний	Эцсийн		Эхний	Эцсийн
А.Хөрөнгө	Х	Х	Б.Өр төлбөр ба эзэмшигчийн өмч	Х	Х
1.Эргэлтийн хөрөнгийн дүн			1.Өр төлбөрийн дүн		
-Мөнгөн хөрөнгө			-Богино хугацаатай өр, төлбөр		
-Богино хугацаатай хөрөнгө оруулалт			-Урт хугацаатай өр төлбөр		
-Авлага			Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр		
-Бараа, бэлэн бүтээгдэхүүн			П.Өмчийн дүн		
-Үндсэн ба туслах материал			-Төрийн		
-Урьдчилж төлсөн тооцоо			-Хувийн		
-Бусад			Ш.Хувьцааны дүн		
П.Биет хөрөнгийн дүн			-Энгийн хувьцааны тоо,ширхэг		
-Барилга байгууламж			-Нэрлэсэн үнэ		
-Газар			-Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг		
-Машин, тоног төхөөрөмж			-Нэрлэсэн үнэ		
-Тавилга, эд хогшил			-Халаасны хувьцааны дүн		
-Хуримтлагдсан элэгдэл					
-Бусад			1Ү.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг		
Ш.Биет бус хөрөнгийн дүн			Ү.Хуримтлагдсан ашиг		
1Ү. Урт хугацаатай хөрөнгө оруулалт			Ү1.Эзэмшигчдийн өмчийн дүн		
Нийт хөрөнгийн дүн			ҮП.Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн		

Ногдол ашиг тараасан онууд-----

Нэгж хувьцаанд оногдуулсан ногдол ашиг/төг/-----
/Он бүрээр/

/Мян.төг/

Үзүүлэлт	200.	200.	200.
1.Цэвэр борлуулалт			
2.Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг			
3.Үйл ажиллагааны зардал			
4.Ашиг			
5.Хувьцааны арилжааны дундаж ханш			
6.Хувьцааны дансны дундаж ханш			
7.Хувь нийлүүлэгчдийн тоо			
8.Хувьцааны төвлөрлийн хувь			

Гүйцэтгэх захирал / /

Ерөнхий нягтлан бодогч / /

200. оны .. сарын ..-ний өдөр